

**НИЙСЛЭЛИЙН “ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ” ОНӨААТҮГ-ЫН
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАНИЛЦУУЛГА
(2023 оны эхний хагас жил)**

2023 оны 06 дугаар сарын 07

Улаанбаатар хот

НЭГ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Нийслэлийн “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-ын чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэлийн дагуу бүртгэл хяналтад авсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах, цаг хугацаанд нь зохион байгуулах, эрчимжүүлэх, үр дүнг тооцох, урамшуулал, хариуцлагын тогтолцоог нэмэгдүүлэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

ХОЁР.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг дүгнэхдээ хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3-т заасан аргачлалыг баримтлан тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 2023 оны эхний хагас жилийн байдлаар нэгтгэн дүгнэж, үнэлгээ хийсэн.

Үүнд:90-100 хувийн үнэлгээтэй буюу “Бүрэн хэрэгжсэн” –100 хувь, 50-89 хувийн үнэлгээтэй буюу “Хэрэгжих шатанд” –70 хувь, 10-49 хувийн үнэлгээтэй буюу “Хэрэгжилт хангалтгүй” –30 хувь, 0-9 хувийн үнэлгээтэй буюу “Хэрэгжээгүй” –0 хувь, “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” гэсэн аргачлалаар үнэллээ.

ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар

Хүснэгт 1.

№	Баримт бичгийн нэр	Шийдвэрийн тоо	Заалтын тоо	Үнэлгээний хувь				Биелэлтийн дундаж хувь	Ерөнхий үнэлгээ
				90%-100%	50%-89%	10%-49%	0%-9%		
1	Монгол Улсын хууль	9	10	7	2			94,8 хувь	Бүрэн хэрэгжсэн
2	Ерөнхийлөгчийн зарлиг	1	1	1				100 хувь	Бүрэн хэрэгжсэн
3	Засгийн газрын тогтоол	1	2	1				100 хувь	Бүрэн хэрэгжсэн
4	Нийслэлийн Засаг Даргын захирамж	5	6	1	2	2		63 хувь	Хэрэгжих шатанд
5	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгавар	1	1	1				100 хувь	Бүрэн хэрэгжсэн
Нийт дүн		17	20	11	4	2		91,6 хувь	

Хууль тогтоомж,тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ,үнэлгээний ажлын хүрээнд Монгол улсын хууль,Ерөнхийлөгчийн зарлиг,

Засгийн газрын тогтоол, Нийслэлийн Засаг Даргын захирамж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгавраас өгсөн нийт 17 шийдвэрийн 20 заалт тус үйлдвэрийн газарт "Бүрэн хэрэгжиж" буюу 91,6 хувийн биелэлттэй байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 43 дугаар тогтоолын 1.7 заалт Нийтийн тээврийн хэрэгслийг цахилгаан болон хийн түлшний хэрэглээнд үе шаттай шилжүүлэх ажлын хүрээнд байгууллагын хэмжээнд туршилтын гэрээгээр БНХАУ-ын "Skywell" үйлдвэрийн 37 дан, 2 давхар 10 нийт 47 цахилгаан автобус, цахилгаан цэнэглэх 4 цэг ашиглалтад оруулсан. 112 ширхэг евро-5 түлшээр ажилладаг Хятад улсад үйлдвэрлэсэн "Нанжин Голден Драгон Бус" автобусаар парк шинэчлэлт хийж, үйлдвэрийн газрын 184 тээврийн хэрэгслээс 159 буюу 86,5%-ийн бүрэн шинэчлэгдсэн. 2022 онд ашиглалтын хугацаа дууссан каунти маркын 25 ширхэг автобус нь нийслэл хотын агаарын бохирдолд нөлөөлж байгаа бөгөөд байгаль орчинд ээлтэй нийтийн тээврийн автобусаар парк шинэчлэлтийг хийх шаардлагатай гэж үзэж байна.

Тайлант хугацаанд Монгол Улсын хууль, Засгийн газрын тогтоол, Нийслэлийн Засаг Даргын захирамж, албан үүрэг даалгавруудын хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжүүлж ажилласан гэж дүгнэж байна.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр хэрэгжих шатанд болон хэрэгжилт хангалтгүй байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтыг байгууллагын хэлтсүүд гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусгаж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах. Хэрэгжих шатандаа явж байгаа шийдвэрийн заалтын ажлуудыг эрчимжүүлэхийг Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэст зөвлөж байна.

Байгууллагын 2023 онд хийх парк шинэчлэлтийн ажлын хүрээнд цахилгаан автобус болон цахилгаан цэнэглэх цэгийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах.

ХЯНАСАН: ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА  Л.ОТГОНБААТАР

ТАЙЛАН ГАРГАСАН: ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН АХЛАХ АЖИЛТАН  Б.ОЮУНЦЭЦЭГ

**“ЗОРЦИГЧ ТЭЭВЭР ГУРАВ” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР
2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУУЛЬ ТОГТОМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2023 оны 06 дугаар сарын 05					Улаанбаатар хот	
Д/д	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Биелэлт	Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан	
1	2	3	4	5	6	
1. Монгол Улсын хууль						
1.1	1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэг	Авлигын эсрэг хууль 2006.07.06	1.1.Газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/24 дугаар тушаалаар Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, 5 зорилгын хүрээнд 17 арга хэмжээ төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж, авлига, ашиг хонжоо, давуу байдлаас ангид байх, олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хангагдаж байна.	99%	Үгүй	
1.2	30 дугаар зүйл	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай 2019.06.06	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хуулийн этгээдийн хүлээх нийтлэг үүргийн дагуу “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын 2023 оны төлөвлөгөө” батлан гэмт хэрэг, зөрчил гарч буй шалтгаан нөхцөлийг тодруулж, түүний мөрөөр урьдчилан сэргийлэх арга хэмжээ аван холбогдох захиргааны байгууллага, төрийн тусгай албатай хамтран сургалт, сурталчилгаа мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Дээрхийн үр дагаварт зам тээврийн ослын тоо болон эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн гаралт буурах санаатай гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байна. Мөн 2022 онд бүртгэлтэй тээврийн хэрэгслийн зам тээврийн ослын тоо 2023 оны бүртгэлтэй тээврийн хэрэгслийн тоонд харьцуулахад 5 дугаар сарын байдлаар 25 хувиар бууруулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан байна.	84%	Үгүй	

1.3	1 дүгээр зүйл	Жолоочийн даатгалын тухай 2011.10.06	Нийтийн тээврийн автобусны жолооч нь хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцад эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэгт холбогдох, зөрчлийн тухай хуульд заасан зөрчилд холбогдож бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсан тохиолдолд нөхөн төлбөрийг хуулийн дагуу барагдуулж байна. 38,833,782 (гучин найман сая найман зуун гурван мянга долоон зуун наян хоёр) төгрөгийг хохирол барагдуулсан.	100%	Үгүй
1.4	16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай 1995.04.17	Үйлдвэрийн газарт нийт 238 өргөдөл, гомдол бүртгэгдсэн ба ННЗБ системд 237 өргөдөл, гомдол, 1800-1200 дугаарт 1 өргөдөл, гомдол бүртгэгдсэнээс 161 өргөдөл, гомдлыг 5 хоногт багтаан 67.54%, 67 өргөдөл, гомдлыг 10 хоногт багтаан 28.27%, 7 өргөдөл, гомдлыг 15 хоногт багтаан 2.95%, 3 өргөдөл, гомдлыг 30 хоногт багтаан 1.27% тус тус шийдвэрлэж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоног 3 цаг бөгөөд хуулийн хугацаанд хянан шийдвэрлэсэн.	100%	Үгүй
1.5	20 дугаар зүйл	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 1996.05.27	Үйлдвэрийн газрын дарга өөрт олгогдсон эрх, үүргийн хүрээнд өдөр тутмын үйл ажиллагаандаа уг хуулийг удирдлага болгон хэрэгжүүлж үйл ажиллагааны үндсэн чиглэлээр (А) 41, хүний нөөцийн чиглэлээр (Б) 318 тушаал гарган хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан.	100%	Үгүй
1.6	1 дүгээр зүйл	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль 2005.12.01	Үйлдвэрийн газар нь өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрөө, өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар бие даан иргэний гүйлгээнд оролцож 25 нээлттэй тендер зарлахаас 11 нээлттэй тендерийг цахимаар зарлан, үр дүн гарч 7 гэрээ байгуулагдсан байна.	75%	Үгүй
1.7	3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалт	Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022.04.29	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан, батлуулж, 10 арга хэмжээ төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	98%	Үгүй
1.8	1-13 дугаар бүлэг	Хөдөлмөрийн тухай хууль 2021.07.02	Үйлдвэрийн газар нь ажилтан, ажил олгогч нарын хөдөлмөр эрхлэлтийн харилцааг Хөдөлмөрийн тухай хуулийн хүрээнд хэрэгжүүлэн, мөрдөн ажиллаж, иргэн хуулийн этгээдийн эрх ашиг сонирхлыг хамгаалан, үйлдвэрийн газарт ажиллаж буй 376 ажилтан, албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ байгуулсан.	99%	Үгүй

1.9	4 дүгээр зүйл	Нийгмийн даатгалын тухай 1994.05.31	2023 оны II дугаар улирлын эхний хагас сарын байдлаар 385 ажилтныг нийгмийн даатгалд хамруулж, Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд 329 ажилтан, Хүүхдээ асарч буй чөлөөтэй 8 ажилтан, Тэтгэвэр тогтоолгосон ажиллагчид 33, бусад 15 ажилтныг даатгуулагчийн төрлөөр ангилан албан журмын даатгалд хамруулж байна.		Үгүй
Хэсгийн дундаж: хувь:94,8%					
2. Ерөнхийлөгчийн зарлиг					
2.1	1	Дугаар 58 Засгийн газарт чиглэл өгөх тухай (Тэрбум мод) 2021.10.04	Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 24 дүгээр хороо "Бумбат рашаан"-д 2021 онд 100 ширхэг мод, 2022 онд 100 ширхэг мод нийт 200 модыг арчлан хамгаалсан.	100%	Үгүй
Хэсгийн дундаж: хувь:100%					
3. Засгийн газрын тогтоол					
3.1	4.1, 4.2	Дугаар 311 "Нийтлэг журам батлах тухай (аанб-ын дотоод хяналт шалгалт)" 2011.11.09	Үйлдвэрийн газрын даргын баталсан төлөвлөгөөний дагуу удирдамжтай 1, төлөвлөгөөт 7, төлөвлөгөөт бус 1, онлайн камераар хийсэн стандарт мөрдөлтийн шалгалт 5 нийт 14 хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж, ажлын үр дүнг газрын даргад танилцуулан холбогдох хэлтэст зөрчлийн хуудас, зөвлөмжийг хүргүүлэн ажилласан. Хийсэн хяналт шалгалтаар нийт 286 зөрчил илрүүлж, холбогдох хэлтэс албан тушаалтанд зөвлөмж хүргүүлж, зөрчлийг нэгээр бууруулж ажилласан.	100%	Үгүй
Хэсгийн дундаж: хувь:100%					
4. Нийслэлийн Засаг даргын захирамж					
4.1	1, 1.5	Дугаар А/32 Төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 2023.01.16	СХД-ийн 33 дугаар хороонд баригдаж буй Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын Автобус паркийн барилга угсралтыг 12 хуулийн этгээд гүйцэтгэж, барилга угсралтын ажил 65 хувь байна.	65%	Үгүй
4.2	2	Дугаар А/111 Албан хэрэг хөтлөлтийн "eDoc" систем ашиглах журам батлах тухай 2023.02.07	E-DOC программ ашиглан үйлдвэрийн газрын хэмжээнд 203 албан бичгийг явуулж, 175 албан бичиг хүлээн авч, өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байна.	100%	Үгүй

4.3	3	Дугаар А/194 Стратегийн команд штабын сургууль зохион байгуулах тухай 2023.03.10	Стратегийн команд штабын сургуулийн ажлыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	40%	Үгүй
4.4	1	Дугаар А/358 Нийслэлийн Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг шинэчлэн байгуулах тухай 2023.04.12	Гамшиг, ослын үед нэрвэгдсэн иргэд, гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэж буй ажилтан, алба хаагч нарыг нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах үүргийн хүрээнд бэлгэл ажлыг ханган ажиллаж байна.	30%	Үгүй
4.5	1	Дугаар А/444 Ажлын хэсэг байгуулах тухай 2023.05.04	Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгах санал болох: Цахилгаан эх үүсвэрээр цэнэглэдэг тээврийн хэрэгслээр парк шинэчлэлт хийх, Цахилгаан эх үүсвэрээр цэнэглэдэг тээврийн хэрэгслийг цэнэглэх цэг нэмж байгуулах саналыг хүргүүлсэн.	80%	Үгүй
Хэсгийн дундаж: 63 хувь					
5. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгавар.					
5.1	3	Дугаар 06 Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд 2023.04.07	Үйлдвэрийн газарт нийт 238 өргөдөл, гомдол бүртгэгдсэнийг 4 хоног 3 цагт хянан шийдвэрлэж, хуулийн хугацаанд хариу хүргүүлсэн.	100%	Үгүй
Хэсгийн дундаж: 100 хувь					
Нийт дундаж: 91,6 хувь					



О.ГАНБААТАР
П.АЛТАНТӨГС
Ц.ЦЭНДСҮРЭН

ТАНИЛЦСАН: "ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ" ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
ХЯНАСАН: ЗАХИРГАА УДИРДЛАГА, ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
ТАЙЛАН ГАРГАСАН: ХУУЛИЙН ЗӨВЛӨХ